

Г.Хосбаяр - Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын тэнхимийн
дэд профессор, хууль зүйн магистр, хошууч

ХОРИХ БАЙГУУЛЛАГАД МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨТ БОДИС НЭВТРЭХЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛЛАГАА, АНХААРАХ АСУУДАЛ

Хураангуй. Нийтлэлд сэтгэцэд нөлөөлөх эм, бодис бэлдмэл, хэрэглээний цар хэрэг, ургалтын тархац орчин болон хорих ял эдлүүлэх ажиллагаанд нөлөөлөх сөрөг нөлөөлл, цаашид анхаарах асуудлын талаар авч үзэн судлаачийн саналыг илэрхийлсэн.

Төлхөөр г. Хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бодис бэлдмэл, хорих ял эдлүүлэх ажиллагаа, хорих байгууллагын харуул хамгаалалт, анхаарах асуудал.

Оршил

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын¹ 3.4.4.1-д “Иргэдийн терроризм, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хэчирхийллээс хамгаалагдах нөхцөлийг сайжруулна” гэж, 3.4.4.3-т “Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус хэрэглээтэй тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлнэ” гэж, 3.4.4.4-т “Нийгэмд эдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаархи сургалт, сурталчилгааг эрчимжүүлж, олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлнэ” гэж, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн² 4.3.4-т “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ” гэж тус тус заасан.

Манай улсын төрөөс мансууруулах бодисын талаарх олон улсын санал, санаачилга болон үүрэг, зорилтыг хангахын төлөө хэчин чармайлт гаргаж ирсэн бөгөөд 2002 онд Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг баталж, 2002 онд баталсан Эрүүгийн хуульд дээрх төрлийн гэмт хэрэгт хөтөлгөх хариуцлагыг бий болгож, 2000-2005 онд “Хар тамхи, мансуурахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”, 2017 оноос “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

“Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”
<https://www.legalinfo.mn/law/details/6163>

² “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
<https://www.legalinfo.mn/annex/71awid-12120>

Европын холбооны улс орнуудад метамфетамин агууламж бэхий мансууруулах бодис, кокаин, героин, Азид “ICE” буюу метамфетамин агууламж бэхий мансууруулах бодис, героин, кокаин, LSD, Тв азид каннабисийн хэрэглээ нсч, улмаар хууль бус йлдвэрлэл болон эмийн хэрэглээ нэмэгдсээр байна.

Хн худалдаалах, мансууруулах бодис наймаалах, нийгмийн аюулгй байдлын эсрэг гэмт хэрэг, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, тх соёлын дурсгалт зйлсийн хууль бус эргэлт, терроризм, хууль бус цагаачлал, зохион байгуулалттай блэг, гэмт блэглэл байгуулах гэмт хэргд байнга йлдэгдэх болсон блгд тэдгээрийн санхгийг эх свэрийг мансууруулах болон сэтгэцэд нллт бодисын хууль бус эргэлтээс олдог бохир мнг блрддэг байна.

Слийн жилдэд БНХАУ, ОХУ, Европын Холбооны Улс болон Зн мнд Азийн орноос амфетамин, метамфетамин трлийн болон мансууруулах ургамлын гаралтай бодисыг Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрлсэн, нэвтрлэхийг завдсан, зарж борлуулсан гэмт хэрэг, зрчлийн тоо ихсэх болсон блгд цагдаа, хил, гаалийн байгууллагаас ирлсэн мэдээллээс зэхэд БНХАУ-аас ихэвчлэн амфетамин, метамфетамин трлийн мс (ICE) болон мансууруулах ургамлын гаралтай шавар (Hashish), ОХУ-аас сэтгэцэд нллт анданте зэрэг эм хууль бусаар нийллэх болжээ. Манай орны зарим нутаг дэвсгэрт ургадаг мансууруулах болон донтуулах йлчилгээтэй бодис бхий ургамал болох намуу, зэрлэг олс, зээргэнэ, лантанз зэрэг 9 овог, 11 трлд хамаарах 18 зйл ургамал нь манай улсын 14 аймгийн 49 гаруй сумын нутаг дэвсгэрт 15,000 орчим га талбайд ургадаг гэсэн судалгаа байдаг блгд тнийг механик аргаар устгахад 1 га талбайд гарах зардлыг 53,300 тгр, химийн аргаар устгахад 40,300 тгр тус тус байхаар холбогдох мэргэжлийн байгууллагаас тооцон гаргасан боловч тсв, санхгийг байдлаас шалтгаалан дээрх трлийн ургамлыг устгах ажил хангалтгй хийгдэж ирсэн¹. Тнчлэн ххэд, залуучууд бие биеэ даган дуурайх, цахим слжээнд энэ тухай мэдээлэл хяналтгй цацагдах, гэмт хэрэгтэй тэмцэх мэргэжлийн байгууллагын уялдаа холбоо муу, одоо ашиглаж байгаа техник, тоног тхрмж нь орчин ейин хэрэгцээ, шаардлагыг хангахгй болсон, энэ трлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх йл ажиллагаа хангалтгй, хэрэглэгч, донтогч болсон хнд зллэх эмнэлгийн, сэтгэл зйн болон нийгмийн тусламж, йлчилгээний стандарт байхгй зэрэг нь манай улсад хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн тоо нсн нэмэгдэхэд срглр нлж байна.

■ НДСЭН ХЭСЭГ

Илтгэлийн зорилготой уялдуулан эрүүлгийн ял эдлүүлэх эрх зүйн холбогдох зарчим, түүрхс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой тэмцэх чиглэлд баримтлаж буй бодлого, хорих ял эдлүүлэх, хоригдолд хяналт тавих харилцааг зохицуулж байгаа эрх зүйн эх сурвалжийн зарим хэм хэмжээ, хорих ял эдлүүлэх байгууллагын ангилал, мөн гарч болзошгүй эрсдлийн талаар товч авч үзье. Энэ нь:

-Хорих ял эдлүүлэх ажиллагаа ялын зорилгыг хангахад захирагдах, хоригдолд байнгын, үр нөлөөтэй хяналт тавих зарчим;

-Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.4 /Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ” /;

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 241.1 /”Хорих ангийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь... техникийн хяналт, хамгаалалт, биечилсэн хяналт, хамгаалалт... гэсэн бүрэлдэхүүн хэсэгтэй байна”/, 243.3 /”Хоригдол, хорих ангийн алба хаагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хорих үр, хорих анги дотор хоригдол зорчих бусад хэсгийг хамарсан дуударсний бичлэгийн хяналтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зохион байгуулна

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн 267 зүйлийн 267.2 /“Хорих байгууллага нь хорих ялыг албадан эдлүүлэх; /267.2.1/, хоригдлын аюулгүй байдлыг хангах, тэдний дунд хууль ёс, дэг журмыг сахиулах, хоригдол бусад этгээдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх; /267.2.2/, хоригдолд хөмүүлжийн нөлөө үзүүлэх; /267.2.3/, хоригдлыг хөдөлмөрлүүлэх, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр хоригдолд дадлага олгох; /267.2.4/ зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг”/, 272 зүйлийн 272.1.3 /“Хорих байгууллагын алба хаагч ... хоригдол, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн бие, эд зүйл, байранд үзлэг, нэгжлэг хийх, зэвсэг, хутга, мэс, зэвсгийн чанартай бусад зүйл, мансууруулах болон хордуулах үйлчилгээтэй эм, тариа, үвс ургамал, согтууруулах ундаа, хориглосон тоглоом, хууль, дотоод журмаар зөвшөөрөгдсөн бусад зүйлийг хураан авах, эсхүл устгах, бэлэн мөнгө, валют, үнэт зүйлсийг хураан авч акт тогтоон хадгалах, хорих ангийн аюулгүй байдал, түүнд мөрдөгдөх дэг журмыг сахиулах зорилгоор хоригдол, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид байнгын хяналт тавих; . бүрэн эрх эдэлнэ” /;

-“Хорих ангийн харуул хамгаалалтын журам”-ын 1 зүйлийн 1.4 /“Харуул хамгаалалтыг хорих ангийн байршил, дэглэм, зэрэглэл, алба хаагчдын орон тоо, зохион байгуулалт, хамгаалалтын бүс, байгууламж,

¹ “Хар тамхины гэмт явдал: шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам

инженер, техникийн хэрэгсэл, хоригдлын тоог харгалзан биечилсэн хяналт-хамгаалалт, гадна хамгаалалт гэсэн хэлбэрээр зохион байгуулна” / зүйл тус тус болно.

Монгол Улсын талаар НҮБ-ын шинжээчдийн хийсэн нэлгээнд героин, амфетамин, каннабис, экстазийн тэргийн мансууруулах бодисын хэрэглээ нэмэгдэж, тархацын хувьд каннабис хамгийн их, намуугийн тархалттай, экстазийн урсгал БНХАУ-аас чиглэсэн, героин, амфетамины тэргийн бодисын худалдааны замууд дайран нэвчрч байна гэж үзсэн.

Мөн тус байгууллагын 2016 оны тайланд дурьдсанаар Монгол Улс нь хар тамхи, мансууруулах бодис “Дамжин нэвчрч улс” гэж үзэж байсан бол НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-ын тайланд дурьдсанаар манай орныг “Хэрэглэгч улс” орон болсон гэж дүгнэсэн.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 20.7-д заасан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах”, 20.8-д заасан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах”, 20.9-д заасан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших”, 20.10-д заасан “Мансууруулах нийлчилгээ бэхий ургамлыг хууль бусаар тариалах” зэрэг нийлдлийг гэмт хэрэгт тооцож, дээрх нийлдэлд эрх хасах, зорчих эрх хязгаарлах, торгох, хорих ял оногдуулахаар хуульчилсан.

Олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг

1 “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах Эрх хасах 1-5 жил зорчих эрх хязгаарлах, 40.000-200.000 нэгжээр торгох, 1-20 жил эсхүл бэх насаар хорих ял;

2 “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах” 1-5 жил зорчих эрх хязгаарлах, 5400-27.000 нэгжээр торгох, 1-12 жил хорих ял;

3 “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших” 2-5 жил эрх хасах, 1-5 жил зорчих эрх хязгаарлах, 5400-27.000 нэгжээр торгох, 1-5 жил хорих ял;

4 “Мансууруулах нийлчилгээ бэхий ургамлыг хууль бусаар тариалах” Эрх хасах 1-5 жил зорчих эрх хязгаарлах, 40.000-200.000 нэгжээр торгох, 1-12 жил хорих ял

Улсын хэмжээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын Эрүүгийн хуулийн 20.7-д заасан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах”, 20.8-д заасан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэх орон байраар хангах”, 20.9-д заасан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг завших”, 20.10-д заасан “Мансууруулах нийлчилгээ бэхий ургамлыг хууль бусаар тариалах” зэрэг 211 хэрэгт 181 хүн холбогдон

шалгагдсан нь урьд оны мөн өөс 11 хэргээр буюу 6.5 хувиар, холбогдогч 57 хүүхдээр буюу 37 хувиар тус тус өссөн байна.

Гэмт хэргийн холбогдогчдын насны байдлаар авч үзвэл 17 нас буюу насанд хэрэггүй этгээдийн тоо 2 дахин, 19-25 насны холбогдогч 37.8 хувиар, 26-35 насны холбогдогч 88 хувиар, 35-аас дээш насны холбогдогч 20.08 хувиар тус тус өссөн байна.

Монгол Улсын хэмжээнд энэ төрлийн гэмт хэргийн гаралт, хэрэглэгч, нийлүүлэгчдийн тоо нэмэгдэхийн хэрээр ял шийтгэгдсэн хоригдлын тоо жил ирэх тусам нэмэгдсээр байна.

Хорих байгууллагад 2003 онд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэж ял шийтгэгдсэн 1 хоригдол ял эдэлж байсан бол 2020 оны жилийн эцсийн байдлаар 163 хоригдол, 2021 оны 09 сарын 21-ний төдрийн байдлаар 51 хоригдол ял эдэлж байна. Тухайн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн хоригдлын тоо буурсан шалтгаан нь өршүүл үзүүлэх тухай хууль батлагдан гарсантай холбоотой болно.

Хорих ял эдэлж байгаа хоригдлын дийлэнх нь буюу мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг удаа дараа хэрэглэсэн, биедээ хадгалсан, худалдан борлуулсан зэрэг үйлдлийн шинжтэй байгаа нь хорих байгууллагад энэ төрлийн гэмт хэргийг үйлдэж болзошгүй гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Хар тамхины гэмт хэргийн 50 орчим хувь нь дотоодод ургаж байгаа үвс, ургамалтай холбоотой бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт 15000 га газар буюу 14 аймагт мансууруулах бодис оролцсон ургамал ургадаг. Монгол орны ургамлын аймагт ургадаг намуу, олс, зээргэнэ, лантанз зэрэг 9 овог, 11 төрөлд хамаарах 18 зүйл ургамал мансууруулах, донтуулах (хар тамхи, сэтгэцэд нөлөөт) үйлдэлтэй.

Таримал олс, ургамал тархацын цэгцүйдийг засаг захиргааны нэгжээр хуваан авч үзвэл:

1. Сэлэнгэ аймгийн Шаамар, Мандал (Зүүнхараа), Баянгол (Баруунхараа) сум;
2. Дархан-Уул аймгийн Хонгор сум;
3. Орхон аймгийн Эрдэнэт хотын орчим;
4. Төв аймгийн Сүмбэр(Октябрь), Жаргалант, Борнуур;
5. Булган аймгийн Сэлэнгэ, Орхон, Хялганат, Дашинчилэн, Рашаант;
6. Хэнтий аймгийн Батноров, Дадал;
7. Дорнод аймгийн Халхгол, Баян-Уул, Баяндун, Матад;
8. Сүхбаатар аймгийн Халзан, Эрдэнэцагаан сумд;
9. Увс аймгийн Зүүнговь зэрэг сумд;
10. Ховд аймгийн Булган сумын нутгуудад өргөн тархацтай байна.

Мансууруулах ёйлчилгээний таримал олс, ургамлын тархацын байршил нь тлвлрсн бтэцтэй хорих анги, цагдан хорих байр болон ял эдэлж байгаа хоригдлын гэмт зан ёйлд нлллх эрсдэлт хчин зёйлийг бий болгож байна. Мн хорих ангиудад мансууруулах эм, сэтгэцэд нллт бодис хэрэглэсэн, худалдан борлуулсан, хадгалсан гэмт хэрэг ёйлдсэн хоригдлуудыг нэг дор хорих нь тёнийг бусад сурталчлах, хорих ангийн байршилд нэвтрёлэх ёйлдэл хийгддэг бгд хорих байгууллагын хэвийн ёйл ажиллагааг алдагдуулж болзошгё эрсдлийг нэмэгдёлж байна.

Шёёхийн шийдвэр гёйцэтгэх байгууллага нь Цагдаагийн ерёний газрын Хар тамхитай тэмцэх газартай хамтран мансууруулах эм, сэтгэцэд нллт бодистой холбоотой гэмт хэрэг ёйлдсэн хоригдлын хувийн мэдээлэл, гэмт зан ёйл, анхаарал татсан яриа ёглёл, хань харилцааг нь илрёл чиглэлээр мэдээлэл солилцож хамтран ажилладаг бгд хорих байгууллагад мансууруулах эм, сэтгэцэд нллт бодис нэвтрэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор судалгаа тандалт, гёйцэтгэх ажлын хяналт, ёзлэг, нэгжлэгийг ажлыг зохион байгуулж байна.

Шёёхийн шийдвэр гёйцэтгэх байгууллагын зёгээс мансууруулах эм, сэтгэцэд нллт бодистой холбоотой гэмт хэрэг ёйлдсэн хоригдлын тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан ял шийтгэгдсэн хоригдлуудын зан ёйл, хдлгёён байршилд хяналт тавьж сар бёр шээснээс илрёл тестийг тогтмол авч байна. Хорих байгууллагад мансууруулах эм, сэтгэцэд нллт бодис нэвтрёлэхээс урьдчилан сэргийлэхэд алба хаагчдын мэдлэг, ур чадвар чухал бгд албаны сургалтыг тогтмол, мэргэшёл чиглэлээр зохион байгуулах шаардлагатай.

Хорих байгууллагад мансууруулах эм, сэтгэцэд нллт бодисыг илрёл чиглэлээр мэргэшсэн боловсон хчин дутмаг, алба хаагчдын мэдлэг, ур чадвар хангалтгёй, шаардлагатай техник, технологи дутмаг байгааг дурьдах нь зёйтэй. Хорих байгууллагад энэ тёрлийн гэмт хэрэг ёйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хоригдлын дунд нлллийн сургалт, арга хэмжээг тогтмол зохион байгуулах, алба хаагчдын мэдлэг ур чадварыг нэмэгдёлх, мансууруулах эм, сэтгэцэд нллт бодисын ойлголт, хэлбэр, тёрлийг таниулах сургалтыг тогтмол зохион байгуулах нь нэн тэргёний урьдчилан сэргийлэх ажил юм.

Гадаадын зарим орнуудад хорих байгууллагын хамгаалалтын бсэд хар тамхи, мансууруулах бодис, гар утас, бэлэн мёнг, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, согтууруулах ундаа зэрэг хориотой эд зёйлсийг дроноор тээвэрлэж хоригдол, хоригдогч нарт дамжуулах ёйлдлёл гарч байна.

Дүгнэлт

Хорих байгууллагад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис нэвтрэхээс урьдчилан сэргийлэх ажиллагаа, анхаарах асуудалд тулгуурлан дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- Энэ төрлийн гэмт хэрэгт холбогдон шүүхээс хорих ял шийтгүүлсэн этгээдийн тоон эзлэлт тогтмол бич байгаа нь хорих байгууллагын өмнө тулгамдаж буй асуудлыг нэг бөгөөд тэдэнд эзлэх нөлөөллийн болон харуул хамгаалалтын хич, арга хэрэгслийг боловсронгуй болгох, алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтуудыг тогтмол явуулах хэрэгцээ, шаардлага байна;

- Хорих байгууллагын алба хаагч нар энэ төрлийн бодисыг таниулах, илрүүлэх арга зүйн сургалтыг хангалттай зохион байгуулдаггүй бөгөөд 1 жилд 1 удаа нийт алба хаагчдын дунд зохион явуулах нь үр дүнгүй байна;

- Хорих байгууллагад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх арга зүйг тусгасан эрх зүйн баримт бичиг боловсруулж мөрдүүлэх шаардлагатай.

Санал

Иймд хорих байгууллагад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис нэвтрэхээс урьдчилан сэргийлэх ажиллагаатай холбоотой дараах зохицуулалт, практикийг бий болгохыг санал болгож байна. Энэ нь:

1. **Хяналт, шалгалтын талаар:** Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хорих байгууллагад нэвтрүүлэхээс сэргийлэх ажиллагаанд албаны нохойг тусгайлсан сургалтаар сургаж ашиглах, илрүүлэгч багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжүүр хангах;

2. **Хүний нөөцийг бэлтгэх, мэргэшүүлэх, чадавхжуулах талаар:** Харуул хамгаалалтын алба хаагчдад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын тухай ойлголт, төрөл, хэлбэр, шинж чанарын талаарх танин мэдэхүйн мэдлэг, илрүүлэх ур чадварыг эзэмшүүлэх, мэргэшүүлэх, гадаадын зарим орны ижил төстэй байгууллагуудад хамтран ажиллах, туршлага солилцох, мэргэжилтэн бэлтгэх;

3. **Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны талаар:** Хорих байгууллагад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх ажиллагаатай холбоотой гадаадын орнуудын эрх зүйн зохицуулалт, практикийг судлан дэвшилтэд хэм хэмжээ, жишгийг өөрийн орны нөхцөл байдалд нийцүүлэн нутагшуулан хэрэгжүүлэх, мөн сөрөг үзэгдэл, үйл ажиллагаанаас¹ сургамж авч холбогдох урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, тэмцэх арга хэмжээг авах шаардлагатай болно.

¹Хорих ял эдлүүлэх байгууллагын хамгаалалтын бөсөд хар тамхи, мансууруулах бодис, гар утас, бэлэн мөнгө, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, согтууруулах ундаа зэрэг хориотой эд зүйлсийг дроноор тээвэрлэж хоригдол, хоригдогч нарт дамжуулах үйлдлүүд гарч байна.